

БАТЛАВ:  
ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА  
О.БАТЖАРГАЛ  
2021 оны 11 дүгээр сарын 11 өдөр

БАТЛАВ:  
“ДОНШЕН ГАЗРЫН ТОС (МОНГОЛ)”  
ХХК-ИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ  
ЖАН ХҮБЭН  
2021 оны 11 дүгээр сарын 11 өдөр

### ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

2021 оны 11 -р сарын 11-ны өдөр

№ 04/2021

Сайншанд хот

Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 430, 2016 оны 179 дүгээр тогтоол, Дорноговь аймгийн хөгжлийн мастер төлөвлөгөө, аймгийн Засаг даргын “Хөгжлийн төлөө хамтдаа 2” 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрүүдийг үндэслэн нэг талаас Дорноговь аймгийг төлөөлж Сайншанд сумын Засаг дарга Ч.Түвшинтөр, нөгөө талаас “Доншен газрын тос (Монгол)” ХХК-г төлөөлж захирал Жан Хүбэн /цаашид компани гэх/ нар харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

### НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү гэрээгээр талууд байгаль орчныг хамгаалах, орон нутгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх, газрын тосны олборлолт, тогтвортой, хэвийн явуулах чиглэлээр хамтран ажиллах, ажлын уялдаа холбоог сайжруулахтай холбогдсон харилцааг зохицуулна.
- 1.2. Компани нь тухайн тусгай зөвшөөрлийн талбай орших сумын байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, орон нутгийн иргэдийн амьдрах орчныг сайжруулах, ажлын байр нэмэгдүүлэх бодитой хувь нэмэр оруулах төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд хамтран ажиллана.
- 1.3. Энэхүү гэрээ нь Монгол Улсын Үндсэн хууль, Байгаль орчныг хамгаалах тухай, Газрын тосны тухай, Газрын тухай, Газрын хэвлийн тухай, Татварын тухай хууль болон бусад хууль, тогтоомжийн хүрээнд явагдана.

### ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ

- 2.1. Хамтран ажиллах гэрээг хэрэгжүүлэхэд Талууд дараах үндсэн чиглэлүүдийг баримтална. Үүнд:
  - 2.1.1. Олборлолт, төслийн бүтээн байгуулалттай холбоотой дэд бүтцийг хөгжүүлэх,
  - 2.1.2. Байгаль орчныг хамгаалах,
  - 2.1.3. Ажлын байрыг нэмэгдүүлэх,
  - 2.1.4. Орон нутгийн жижиг дунд бизнесийн үйл ажиллагааг дэмжих,
  - 2.1.5. Соёлын өвийг хамгаалах.
- 2.2. Нутгийн захиргааны байгууллага нь компанийн үйл ажиллагаанд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана.

- 2.3.Талууд хамтран энэхүү гэрээний 2.1.1-2.1.5-т заасан асуудлаар олон нийтийн хэлэлцүүлэг явуулж болно.
- 2.4.Компани нь тусгай мэргэжил шаардахгүй ажлын байрыг нэн тэргүүнд тусгай зөвшөөрөл бүхий талбайд байрлаж буй сумын иргэдэд санал болгох, дараагийн шатанд зэргэлдээх сумдын иргэдийг ажлын байраар хангах замаар орон нутгийн иргэдийг авч ажиллуулахад анхаарч ажиллана.
- 2.5.Компани нь төслийн үйл ажиллагааны нөлөөлөлд өртсөн орон нутгийн эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах үүднээс орон нутгийн бизнесийг дэмжих төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх талаар хамтран ажиллана.

## **ГУРАВ. ЗАСАГ ДАРГЫН ЭРХ, ҮҮРЭГ**

### **3.1. Ерөнхий зүйлс:**

- 3.1.1 Газрын тосны олборлолт явуулах хугацаанд тус компанид хууль тогтоомжийн хүрээнд төрийн үйлчилгээ үзүүлж, хяналт тавьж ажиллана.
- 3.1.2 Аж ахуйн нэгж, байгууллагын захиалгаар мэргэшсэн ажилтан бэлдэхэд дэмжлэг үзүүлнэ
- 3.1.3 Шинэ ажлын байр нэмэгдүүлж буй ажил олгогчийг урамшуулан дэмжинэ.
- 3.1.4 Компанийг газрын тос олборлох, цаашид үйл ажиллагаагаа тогтвортой, хэвийн явуулахад орон нутгийн холбогдох байгууллага, албан тушаалтны зүгээс шаардагдах үйлчилгээг шуурхай үзүүлж, дэмжлэг үзүүлнэ.
- 3.1.5 Аймаг, сумын хөгжилд оруулсан хөрөнгийн зарцуулалтыг жил бүр тооцож, ил тод мэдээллэнэ.
- 3.1.6 Газрын тосны салбарын хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэн байгаль орчинд ээлтэй дэвшилтэт технологийг бүхий л хэлбэрээр дэмжинэ.
- 3.1.7 Орон нутгийн иргэдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээг аж ахуйн нэгж, байгууллагад сурталчилна.
- 3.1.8 Татварын хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох саналыг хамтран хүргүүлнэ.

### **3.2 Дэд бүтцийг хөгжүүлэх чиглэлээр.**

- 3.2.1 Газрын тосны олборлолт, төслийн дэд бүтцийн үйл ажиллагаатай холбогдуулан гаргасан хүсэлтийг шуурхай шийдвэрлэн компанийн үйл ажиллагааг тогтвортой, хэвийн явуулах нөхцөл бололцоогоор хангана
- 3.2.2 Газрын тосны олборлолтыг жигд, тогтвортой үйл ажиллагааг хангах, өргөтгөх, ашиглахаар гаргасан хүсэлтийг шуурхай шийдвэрлэн, шаардлагатай дэмжлэгийг үзүүлж ажиллана.
- 3.2.3 Газрын тос олборлох үйл ажиллагаанд шаардлагатай газрыг эзэмших, ашиглах хүсэлтийг түргэн шуурхай шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлж хамтран ажиллана.
- 3.2.4 Газрын тос олборлох орчны аюулгүй байдлыг хангах нөхцлийг бүрдүүлсэн эсэхэд хяналт тавьж ажиллана.

### **3.3 Байгаль орчныг хамгаалах чиглэлээр.**

- 3.3.1 Компанийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллах.
  - 3.3.2 Компаниас орон нутагт зохион байгуулж байгаа байгаль орчны чиглэлийн танилцуулга, сургалт, өдөрлөгт иргэд, олон нийтийг идэвхитэй оролцуулах.
  - 3.3.3 Байгаль орчинд ээлтэй, ногоон бизнесийн үйл ажиллагаа, дэвшилтэт технологийг бүхий л хэлбэрээр дэмжих, баталгаажуулахад туслах, урамшуулах.
- 3.4 Хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг нэмэгдүүлэх, ажиллах хүчнийг сургах чиглэлээр.**
- 3.4.1 Компанийн захиалгаар мэргэшсэн ажилтан бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх.
  - 3.4.2 Компанийн зарласан ажлын байрны мэдээллийг иргэдэд ил тод, нээлттэй хэлбэрээр хүргэх ажлыг зохион байгуулах, орон нутгийн телевиз, радио, сонингоор түгээх.
  - 3.4.3 Төслийн бүтээн байгуулалт, туршилт тохиргоо, зүгшрүүлэлтийн ажил, зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээгээр зайлшгүй ажиллах шаардлагатай гадаад, дотоод ажиллагсдын хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх.
- 3.5 Орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулах чиглэлээр.**
- 3.5.1 Компанийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авахтай холбогдсон мэдээллийг иргэдэд хүргэн ил тод, нээлттэй хэлбэрээр хүргэх ажлыг зохион байгуулах;
  - 3.5.2 Компанийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авахтай холбогдсон шалгуур үзүүлэлт, тавигдах шаардлагуудыг орон нутгийн бизнес эрхлэгч, иргэдэд танилцуулахад хамтран ажиллах.

## **ДӨРӨВ. КОМПАНИЙН ЭРХ, ҮҮРЭГ**

### **4.1 Ерөнхий зүйлс.**

- 4.1.1. Газрын тос олборлох, төслийн хүрээн дэх үйл ажиллагааг хэвийн тасралтгүй явуулахад орон нутгийн зүгээс аливаа саад тотгор учруулсан тохиолдолд компани нь холбогдох байгууллагаар уг асуудлыг шийдвэрлүүлэх эрхтэй.
- 4.1.2. Компани нь 2021 онд Дорноговь аймгийн сургууль, цэцэрлэг цахим боловсрол, хичээлийн нөхцөл байдлыг хангах ажлын арга хэмжээний хүрээнд 45 ширхэг компьютерыг орон нутагт хүлээлгэн өгнө.
- 4.1.3. Гамшиг, осол, гал түймэр гарсан үед сайн дурын үндсэн дээр тухайн сум, орон нутагт техник, тоног төхөөрөмж, ажиллах хүчний болон шаардлагатай бусад туслалцаа үзүүлнэ.
- 4.1.4. Газрын тос олборлох үйл ажиллагааг сум, орон нутгийн иргэдэд сурталчилна.

### **4.2 Байгаль орчныг хамгаалах чиглэлээр.**

- 4.2.1 Төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө болон тайланг олон нийтэд танилцуулж, нутгийн иргэдийг мэдээллээр хангах ажлыг тухай бүр нь төсөл хэрэгжиж байгаа сумын болон аймгийн Засаг даргатай хамтран зохион байгуулж ажиллана.
- 4.2.2 Техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг стандартын дагуу чанартай хийж гүйцэтгэнэ

- 4.2.3 Аймаг болон сумдын төрийн байгууллагууд, нутгийн иргэдийг уурхайн нөхөн сэргээлтийн үйл ажиллагаатай танилцуулах ажлыг орон нутгийн захиргааны байгууллагатай хамтран зохион байгуулна.
- 4.2.4 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагддаг агаар, ус, хөрсний шинжилгээг Дорноговь аймаг дахь лабораториудаар жилд 1-ээс доошгүй удаа хийлгэнэ.
- 4.2.5 Ашиглалт, олборлолтын ажлыг ТЭЗҮ, тухайн жилийн ажлын төлөвлөгөө, төсвийн дагуу ажиллана.

#### **4.3 Хөдөлмөр эрхлэлт, ажлын байр нэмэгдүүлэх, ажиллах хүчнийг сургах чиглэлээр.**

- 4.3.1.Компани ажиллах хүчний тодорхой хэсгийг сум, орон нутгаас авч ажиллуулна
- 4.3.2.Компани нь орон нутгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, сургахад орон нутгийн хөдөлмөрийн хэлтэстэй хамтран ажиллах бөгөөд шаардлагатай ажлын байр, тавигдах шаардлагыг тухай бүр олон нийтэд зарлана.
- 4.3.3.Компани нь төслийн үйл ажиллагаа явуулж буй сумдын сургууль, цэцэрлэгийг сайжруулахад дэмжлэг үзүүлж, Дорноговь аймаг болон сумдтай хамтран ажиллана.
- 4.3.4.Хөдөлмөрийн тухай хуулийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй, одой хүнийг ажлын байраар хангах буюу ажиллуулаагүй бол холбогдох хууль, тогтоомжийн дагуу мөнгөн төлбөрийг төлнө.

#### **4.4 Соёлын өвийг хамгаалах чиглэлээр.**

- 4.4.1.Үйл ажиллагааны явцад тусгай зөвшөөрөл бүхий талбайд түүх, соёлын дурсгалт зүйл илэрвэл Соёлын өвийг хамгаалах тухай хууль тогтоомж болон компанийн “Санамсаргүй олдворын үед ажиллах журам”-ын дагуу арга хэмжээ авах ба орон нутгийн ард иргэдийн ёс заншил, өв уламжлалыг хүндэтгэнэ.
- 4.4.2.Орон нутгаас санал болгосон тусгай зөвшөөрөл талбай дэх хэрэгжүүлэх боломжтой соёлын өвийг хамгаалах төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллана.

#### **4.5 Орон нутгийн бизнесийн хөгжилд хувь нэмэр оруулах чиглэлээр.**

- 4.5.1 Орон нутгийн аж ахуйн нэгжийн санал болгосон бараа нь компанийн “Бараа, материал худалдан авах шалгуур үзүүлэлтүүд” болон хэрэгцээ, зориулалт, шаардлага, чанарын үзүүлэлтийг хангаж байгаа тохиолдолд дэмжиж ажиллана.
- 4.5.2 Нутгийн иргэд, аж ахуйн нэгжийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүн хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартын шаардлага хангасан тохиолдолд эхний ээлжинд худалдан авах бодлого баримтлана.
- 4.5.3 Компанид шаардлагатай бараа, материал нийлүүлэх жижиг дунд үйлдвэрийн төсөл, хөтөлбөрийг судлан хэрэгжүүлэх боломжтой төсөл хөтөлбөрийг дэмжиж ажиллана.
- 4.5.4 Гамшиг, осол, гал түймэр гарсан үед сайн дурын үндсэн дээр тухайн сум, орон нутагт техник, тоног төхөөрөмж, ажиллах хүчний болон шаардлагатай бусад туслалцаа дэмжлэгийг үзүүлнэ.

## ТАВ. ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

- 5.1. Гэрээний ил тод байдлыг хангах зорилгоор тухайн орон нутгийн иргэдэд гэрээ байгуулсан талаар мэдээллэх бөгөөд гэрээг аймгийн болон компанийн цахим хуудсанд байршуулна.
- 5.2. Талууд нь Гэрээний биелэлтийг жилд нэг удаа дүгнэх ба Засаг дарга тайланг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулна.
- 5.3. Талууд гэрээний тухайн жилийн биелэлтийн тайланг 2022 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн дотор Ашигт малтмал, Газрын тосны газарт хүргүүлнэ.

## ЗУРГАА. ГЭРЭЭНИЙ ХАРИУЦЛАГА

- 6.1. Талууд үйл ажиллагаандаа Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийг удирдлага болгоно.
- 6.2. Энэхүү гэрээг биелүүлэхэд хоёр тал санаачлага гаргаж ажиллана.
- 6.3. Гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.

## ДОЛОО. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

- 7.1. Гэрээг тайлбарлах болон гэрээний хэрэгжилттэй холбоотой маргаан, зөрчлийг тухай бүр, эв зүйгээр шийдвэрлэхийг эрхэмлэнэ.

## НАЙМ. БУСАД

- 8.1. Талууд гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулсан өдрөөс гэрээ хүчин төгөлдөр үйлчилнэ. Энэхүү гэрээний хүчинтэй хугацаа нь 2021 оны 11 дүгээр сарын 11-ний өдрөөс 2022 оны 03 дугаар сарын 15-ны өдөр хүртэл байна.
- 8.2. Давтагдашгүй хүчин зүйлсийн улмаас гэрээг хугацаанаас өмнө дуусгавар болгож болно. Энэ тухайгаа нэг сарын өмнө нөгөө талд бичгээр мэдэгдэнэ.
- 8.3. Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд зөвхөн бичгээр нэмэлт, өөрчлөлт оруулж болно.
- 8.4. Хэрэв гэрээнд ямар нэгэн өөрчлөлт оруулах шаардлага гарвал нөгөө талдаа 30 хоногийн өмнө харилцан бичгээр мэдэгдэнэ. Оруулсан нэмэлт өөрчлөлтийг гэрээнд хавсаргаснаар нэмэлт, өөрчлөлт нь энэхүү гэрээний нэгэн адил хүчинтэй байх бөгөөд гэрээний салшгүй хэсэг болно.

## ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ДОРНОГОВЬ АЙМГИЙН САЙНШАНД  
СУМЫН ЗАСАГ ДАРГА

УТАС: 99151316



Ч.ТҮВШИНТӨР

“ДОНШЕН ГАЗРЫН ТОС (МОНГОЛ)”  
ХХК-ИЙН ЗҮҮНБАЯНГИЙН  
ҮЙЛДВЭРЛЭЛИЙН БААЗЫН ЗАХИРАЛ  
ЛЮ ГАН

УТАС: 80328286, 80198733, 88585218

